



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нийцлийн аудитын тайлан

**Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн 2015 оны
хэрэгжилт, үр дүн**

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН
ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ ҮНДЭСЛЭЛ
МУУТАЙ ХИЙГДЭЖ ИРСЭН БАЙНА.**

Өлгий

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4
Баян-Өлгий аймгийн Аудитын газар	Бүлэг 1 <i>Нийгмийн халамжийн сангийн төлөвлөлт үндэслэл муутай хийгдэж байна</i>
Дарга, тэргүүлэх аудиторовн албан үүргийг түр гүйцэтгэгч	1.1 Нийгмийн халамжийн сангийн төлөвлөлт үндэслэл муутай хийгдэж байна.....6-9
Х.Бекен	1.2 Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг зохих журмын дагуу бүрдүүлж, хуваарилсан байна10-12
Аудитын менежер	Бүлэг 2 <i>Зарим сангаас олгох тэтгэмжийг хууль зөрчиж олгосон байна.</i>
Х.Женисбек	2.2 Холбогдох хууль тогтоомжийг зөрчиж, 20,0 сая төгрөгийн ихэр хүүхдийн тэтгэмжийг олгосон байна.13-18
Аудитор	2.3 Ахмад настан, ХБИ нийгмийн хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.18-22
М.Айнур	2.4 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсвийг 320,0 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.22-24
Х.Манаргул	Бүлэг 3 <i>Сангийн үйл ажиллагаанд тавих хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.</i>
Д.Назгул	3.1 Сангийн үйл ажиллагаанд тавих хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна25-26
2016 оны 11 дүгээр сар	3.2 Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааг олон нийтэд мэдээлж ажилласан байна26-26
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70422930 дугаарын утас, 70422954 дугаарын факсаар харилцана уу	3.3 Нийгмийн халамжийн сангийн хөрөнгө нь зорилтот бүлэгт бүрэн хүрч байна гэж үзэх боломжгүй байна27-27
ХАЯГ:	Дүгнэлт.....28
Аймгийн ЗДТГазрын байр, 1 дүгээр давхар	Зөвлөмж.....29
	Холбогдох байгууллагын санал:
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал30
	Саналд өгсөн тайлбар

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

Монгол Улсын Ерөнхий аудиторт 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Нийгмийн Халамжийн тухай хууль тогтоомжийн 2015 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалт, түүнд тавих хяналтыг сайжруулах, сангийн хөрөнгийн үр ашиг, хүртээмжийг дээшлүүлэх дүгнэлт, зөвлөмж гарган үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалтын талаар
- Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтын талаар
- Нийгмийн халамжийн сангийн зарцуулалтад тавьж буй дотоод хяналтын талаар

Хамарсан хүрээ

Нийцлийн аудитад Монгол Улсын Их хурал, Засгийн газар, Холбогдох яам, аймгийн ИТХ, Засаг дарга, бусад байгууллагуудаас гаргасан холбогдох шийдвэрүүд, зохион байгуулсан ажлын үр дүн, Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн болон ажлын тайлан, бичиг баримтууд хамрагдлаа.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100-400, 3000, 3100, 4000, 4200, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит, санхүүгийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглав.

Эрсдлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн хийх аудитын эрсдэлийн ерөнхий үнэлгээг “Дунд” гэж үзлээ.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараахь хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Нийгмийн халамжийн тухай хууль
- Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- МУЗГ-ын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам”
- ХХҮГ-ын даргын 2018 онд баталсан нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх аргачлал
- Бусад хууль тогтоомж, журам

Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ахлах аудитор М.Хуанган ахалж, аудитор М.Айнур, Х.Манаргул, Д.Назгул нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг ажиллаж, 2016 оны 9 сарын 05-ноос 9 сарын 27-ны дотор аудитыг төлөвлөгөө, хөтөлбөр, ажлын хуваарийн дагуу хийж гүйцэтгэж, тайлан боловсруулж, батлуулахаар төлөвлөгдсөн боловч ахлах аудитор хувийн шалтгааны улмаас аудитыг удирдаж ажиллаагүй байгаа байдал болон аудитын явцад зарим асуудлыг өмнөх он руу хөөн шалгах шаардлага гарсан нь аудитыг хугацаа хэтрүүлж, сунгаж ажиллахад нөлөөлсөн болно.

Бүлэг 1

*Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төлөвлөлт
үндэслэл муутай хийгдэж ирсэн байна.*

Оршил

Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс нь халамжийн сангийн хөрөнгийг зарцуулах, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх, чиг үүргийг хэрэгжүүлэгч ХХҮЕГ-ын харьяа байгууллага юм.

Нийгмийн халамжийн тухай хууль нь халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний төрөл, хамрах хүрээг тогтоох, нийгмийн халамжийн сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг зарцуулах, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулдаг байна.

Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжууд ахмад насны нийгмийн хамгаалалын тухай, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгаалалын тухай, олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай, МУ-ын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай, хүний хөгжлийн сангийн тухай багц хуулиуд болон холбогдох бусад эрхийн актуудаас бүрдэж байна.

Нийгмийн халамжийн сангаас 2015 онд 3186 хүнд халамжийн тэтгэвэр, 1927 хүнд нөхцөлт мөнгөн тэтгэмж, 1241 хүнд нийгмийн халамжийн дэмжлэг тусламжаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж, 677 хүнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, 5675 ахмад настанд нийгмийн хамгааллын дагуу хөнгөлөлт, тусламж, 1626 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хөнгөлөлт, тусламж, 3124 хүнд жирмэсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж, 10175 хүнд алдарт эхийн одонгийн тусламж, 54 алдар цолтой ахмадуудад хөнгөлөлт тусламжийг тус тус олгож, 5924 хүнийг хүнс тэжээл хөтөлбөрт хамруулсан байна.

1.Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалтын талаар.

1.1 Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төлөвлөлтийн талаар.

Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төлөвлөлт үндэслэл муутай хийгдэж ирсэн байна.

Халамжийн сангийн хөрөнгийн төлөвлөлтийг судлаж үзэхэд санг төлөвлөхдөө өнгөрсөн оны гүйцэтгэл, тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг үндэслэж төлөвлөсний дээр холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд орсон өөрчлөлтийн дагуу халамжийн үйлчилгээний төрөл тус бүрийн мөнгөн дүнд гарсан өөрчлөлтийг нэмэгдүүлэх замаар төлөвлөж ирсэн байна.

Халамжийн сангийн үйлчилгээнд хамрагдаж буй хүний тоо статистик мэдээгээр он оноор гарч байгаа боловч, ирэх онд гарах өөрчлөлтүүдийг урьдчилан тооцох боломжгүй гэж үзэн, урьд онуудын гүйцэтгэлийг төлөвлөгөө хийх үндэслэл болгож ирсэн байна.

Халамжийн үйлчилгээ нь тухайн сумын хүн амд хүрч ажиллах түвшинд байгаа эсэхийг бүтэц орон тоотой нь харьцуулж судалгаа хийж үзэхэд 2014 оны байдлаар 14 сум, нэгжид халамжийн сан хариуцсан 21 мэргэжилтэн ажиллаж байжээ.Тодруулбал: Баяннуур, Дэлүүн, Ногооннуур, Улаанхус сумдын 4794-8001 хүн амд 2, Өлгий сумын 30338 хүн амд 3, бусад сумдын 2592-5216 хүн амд 1 мэргэжилтэн тус тус ажиллаж ирсэн байна.

Сумдад ажиллаж буй нийгмийн халамжийн хэлтсийн мэргэжилтүүд нь тухайн сумын хүн амд хүрч ажиллах бүрэн боломжтой.Харин Өлгий сумд 3 мэргэжилтэн ажиллаж байгаа нь зорилтот бүлэгт хүрч ажиллаж чадахгүй байгаа гэсэн тайлбарыг Халамжийн хэлтсийн удирдлагын зүгээс өгчээ.

Гэхдээ Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн зүгээс тухайн сумын хэмжээнд халамжийн сангаас үйлчилгээ авах боломжтой хичнээн хүн байгаа талаар хийсэн нэгдсэн судалгаа байхгүй байна.

Нийгмийн халамжийн сангийн сүүлийн 2 жилийн төлөвлөлт, гүйцэтгэл, статистик тоон мэдээг үндэслэж, дараах тооцоог гаргаж байна./Жич: Халамжийн сангийн 2013 оны төлөвлөгөө олддоогүй болно/

№	Төрөл	2014 он			2015 он		
		Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Хувь	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Хувь
	Орон нутгийн төсөв	9,803,358,000	8,529,009,459	87	10,981,883,600	9,558,863,344	87
	Улсын төсөв	1,561,810,000	1,529,208,866	98	1,641,000,000	1,557,785,750	95
	Нийт дүн	11,365,168,000	10,058,218,325	89	12,622,883,600	11,116,649,094	88

Халамжийн сан нь 2014 онд гүйцэтгэлээр 10058,2 сая төгрөгийг буюу төсвийн 89 хувийг зарцуулж төсвөө 11 хувиар, 2015 онд гүйцэтгэлээр 11116,6 сая төгрөгийг буюу төсвийн 88 хувийг зарцуулж, төсвөө нийт дүнгээр 12 хувиар тус тус хэмнэсэн байна.

Сангийн гүйцэтгэлийг сүүлийн 3 жилээр харьцуулж үзвэл: 2013 онд 10,3 тэрбум төгрөгийн, 2014 онд 10,0 тэрбум төгрөгийн, 2015 онд 11,1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарчээ. 2015 оны Халамжийн сангийн гүйцэтгэл урьд онуудаас 816,0-1057,8 сая төгрөгөөр буюу 7,8-10,5 хувиар нэмэгдсэн дүнтэй гарчээ.

Сангийн 2015 оны батлагдсан төсвийг урьд оны төсвөөс 11,1 хувиар, гүйцэтгэлээс 25,5 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн байна.Энэ хугацаанд халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй хүмүүсийн судалгааг авч үзэхэд:

Халамжийн сангийн үйлчилгээнд 2013 онд 25319, 2014 онд 25265, 2015 онд 29007 хүн тус тус хамрагдаж, хүний тоо 2014 онд 54-ээр, 2015 онд 3742-оор урьд жилээс нэмэгдсэн байна.

Халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоог халамжийн төрлөөр нь задалж авч үзвэл: Халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжинд хамрагдаж буй хүний тоо урьд жилүүдээс буурсан дүнтэй, бусад үйлчилгээнд хамрагдагсдын тоо өссөн дүнтэй байна.

Халамжийн тэтгэвэр, тэтгэмж үйлчилгээнд хамрагдагсдын тоо буурч байгаа нь ажилласан жил нь гүйцсэн хүмүүс НД-ын тэтгэвэрт шилжин хасагдаж, байгууллагын дотоод хяналтаар зарим шаардлага хангахгүй материалтай хүмүүсийн тэтгэвэр, тэтгэмжийг зогсоосонтой холбоотой байна. Бусад ахмадын хөнгөлөлт, ХБИргэний хөнгөлөлт, алдарт эх, алдар цолтон, ЖНХХЭ тэтгэмжүүдэд хамрагдагсдын тоо жилээс жилд өссөн дүнтэй байна.

Халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн үйлчилгээ авах хүмүүсийн тоо сүүлийн 3 жилийн судалгаагаар буурсан боловч олгох санхүүжилтийн хэмжээ буураагүй байгаа нь тэтгэвэр, тэтгэмжийн мөнгөн дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тухайлбал: Халамжийн тэтгэвэр 2013 онд 103600 төгрөг байсан бол 2014 онд 11400 төгрөгөөр, 2015 онд 11500 төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөн тэжээгчээ алдсаны тэтгэмж 2014, 2015 онд 11500-23000 төгрөгөөр нэмэгджээ. Байнгын асаргаа шаарддаг 16 хүртэлх насны хүүхдийн асаргааны мөнгийг улиралд олгодог байсныг сар болгон олгох болсон нь зарлага санхүүжилтийн дүнг нэмэгдүүлсэн байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээ 2014 оноос эхлэн хэрэгжиж 2014 онд 66 хүн хамрагдаж, 31,4 сая төгрөгийг, 2015 онд 252 хүн хамрагдаж 331,5 сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн хүнс тэжээлийн хөнгөлөлтөнд 2015 онд 950 өрх хамрагдаж, 659,1 сая төгрөг зарцуулсан нь 2015 оны төсвийн гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна.

Аймгийн Статистикийн хэлтсээс хүн амын өсөлттэй холбоотой дараах судалгааг авлаа. Үүнд:

Аймгийн дүнгээр	2011	2012	2013	2014	2015
хүн амын тоо	89,374	88,952	90,878	93,165	101,183

Тус аймгийн 2011-2015 онуудын хүн амын өсөлтийг судлаж үзэхэд 2012 онд өмнөх оноос 5 хувиар буурч, 2013 онд 2,1 хувиар, 2014 онд 2,5 хувиар, 2015 онд 8,6 хувиар өмнөх оноос тус тус өссөн байна.

Аймгийн хэмжээний 101183 хүний 36749 нь хүүхэд, 4643 нь ахмад настан, 59791 нь хөдөлмөрийн насны хүн байна. Шинээр мэндэлсэн хүүхдийн хувьд 2013 онд урьд оноос 25 хувиар өссөн бол 2014, 2015 онуудад 2013 оны түвшингээс нэмэгдээгүй байна. 2014-2015 онд 4461 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байсан байна.

Нийт хүн амын дотор ядуу өрхийн эзэлж буй хувийг дараах хүснэгтээр харууллаа:

үзүүлэлтүүд	2011	2012	2013	2014	2015
өрхийн тоо	20,995	20,773	21,171	22,411	22662
ядуу өрхийн тоо	6,868	6,525	6,304	6,753	6923
үүнээс:нэн ядуу өрхийн тоо	3,690	2,983	3,463	2,833	3497
бүтэн өнчин хүүхэд	346	319	270	253	281
хагас өнчин хүүхэд	2,387	2,313	2,097	1,904	1842
өрх толгойлсон эмэгтэйчүүд	1761	1971	1827	1814	1871

Дээрхи судалгаанаас үзэхэд 2015 онд ядуу өрхийн тоо урьд оноос 2,5 хувиар нэмэгдэж, 2014 онд ядуу өрхийн тоо 2012, 2013 онуудаас 3,6-7,1 хувиар өссөн дүнтэй байгаа боловч 2011 оны дунджаас нэмэгдээгүй байна. 2014 он хүртэл нэн ядуу өрхийн тоо урьд онуудаас буурсан боловч 2015 онд 23,4 хувиар нэмэгдсэн байна. Бүтэн өнчин болон хагас өнчин хүүхдийн тоо 2014 он хүртэл урьд онуудаас буурсан дүнтэй боловч 2015 онд бүтэн өнчин хүүхдийн тоо 11,1 хувиар нэмэгдсэн байна.

Статистик мэдээ судалгаанаас үзэхэд хүн амын тоо 2013-2015 онуудад 2-9 хувиар өссөн боловч шинээр мэндэлсэн хүүхдийн тоо харьцангуй ижил түвшинд байжээ. Ядуу өрхийн тоо 2012-2013 онуудад буурч, 2014-2015 онуудад 2,5-7,1 хувиар өссөн байна. Бүтэн өнчин, хагас өнчин хүүхдүүдийн тоо урьд жилүүдээс буурч, 2015 онд бүтэн өнчин хүүхдийн тоо 11,1 хувиар өссөн байна.

Халамжийн сангийн 2014-2015 онуудад батлагдсан төсвийг үзүүлэлт тус бүрээр харьцуулж үзэхэд: 2015 онд халамжийн тэтгэвэрийн төсвийг урьд оноос 9,14 хувиар бууруулан төсөвлөж, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 67,8 хувиар, нөхцөлт мөнгөн тусламж, хөнгөлөлтийг 6,6 хувиар, ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлтийг 7,3 хувиар, ХБИ-д үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг 25 хувиар, хүнс тэжээлийн тусламж дэмжлэгийг 2,4 дахин, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсвийг 6,2 дахин, жирмэсэн болон хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийг 10,5 хувиар, банкны үйлчилгээний хураамжийг 11,3 хувиар алдарт эхийн одонгийн төсвийг 5,6 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Нийгмийн халамжийн санд орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгөнөөс сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл болон санхүүжилтийн үлдэгдлээс 2014 онд 456,1 сая төгрөгийг, 2015 оны эцэст 222,7 сая төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Дээрх тоо мэдээлэл, судалгааг нэгтгэн дүгнэлт хийж үзэхэд Нийгмийн халамжийн сангийн төсвийг урьд оны гүйцэтгэл, халамжийн үйлчилгээнд хамрагдах ёстой хүний тоо, хүн амын өсөлт, түүн дотор нийгмийн халамжийн үйлчилгээ хүртэх зорилтот бүлгийн судалгаа шинжилгээ хийлгүй, батлагдсан төсвийг нэмэгдүүлэх замаар төлөвлөж ирсэн байна. Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төлөвлөлт үндэслэл муутай хийгдэж ирсэн гэж үзэх бүрэн үндэстэй байна.

1.2 Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалтын талаар.

Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг зохих журмын дагуу бүрдүүлж, хуваарилсан байна.

Нийгмийн халамжийн сан нь арилжааны банкинд 6 данстай бөгөөд улсын төсвийн 2, орон нутгийн төсвийн 4 дансаар дамжуулж орлого зарлагын гүйлгээг хийж ирсэн байна.

Сум тус бүр өөрийн халамжийн сангийн данстай байсныг НХҮЕГ-ын 2015 оны 1/533 албан тоотоор сумын дансны үлдэгдлийг аймгийн төвийн дансанд татан төвлөрүүлж, сумын данснаас олголт хийхийг зогсоож, аймгийн төвийн данснаас олголт хийхийг үүрэг болгосны дагуу 2015 оны 4 сарын 02-ны өдрөөс эхлэн нийгмийн халамжийн сангийн нэгдсэн данснаас зарлага санхүүжилтийг хийж, үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Сангуудын тайлант оны орлогын бүрдүүлэлтийг хүснэгтээр харуулбал:

сан	Санхүүжилтийн орлого	Сангийн чөлөөт үлдэгдэлд бодогдсон хүүгийн орлого	Буцаасан орлого	Бусад эх үүсвэр	Нийт орлого
алдарт эх	1,515,000,000	2,949,163.59	400,000	500,000	1,518,849,163.59
алдар цолтон	126,000,000	221,617.99	400,000	10,000	126,631,617.99
улсын төсвийн дүн	1,641,000,000	3,170,782	800,000	510,000	1,645,480,781.58
халамж	7,252,243,700	5,690,523.05	16,495,760	1,478,010	7,275,907,993.05
хүнс тэжээл	698,742,200	442,810	15,236,000	4,196,410	718,617,420.00
ЖХХХЭТэтгэмж	1,406,228,000	2,061,570.82	2,587,000.00	30.00	1,410,876,600.82
ОНОТХҮйлчилгээ	368,993,877	272,833.18	-	-	369,266,710.18
орон нутгийн төсвийн дүн	9,726,207,777	8,467,737	34,318,760	5,674,450	9,774,668,724.05
нийт дүнгээр	11,367,207,777	11,638,519	35,118,760	6,184,450	11,420,149,506

Тайлант онд Нийгмийн халамжийн сангийн улсын төсвийн 2 дансанд 1645,5 сая төгрөгийн, орон нутгийн 4 дансанд 9774,7 сая төгрөгийг, нийтдээ 11420,1 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Халамжийн сан нь улсын төсвөөс алдарт эхийн санд 1515,0 сая төгрөгийн, алдар цолтны санд 126,0 сая төгрөгийн санхүүжилт, сангийн чөлөөт үлдэгдэлд 3,2 сая төгрөгийн хүүгийн орлого, бусад орлогоос 1,3 сая төгрөгийн орлого хүлээн авч нийтдээ 1645,5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн 4 санд нийтдээ 9726,2 сая төгрөгийн санхүүжилтийг авч, сангийн чөлөөт үлдэгдэлд 8,5 сая төгрөгийн хүүгийн орлого хүлээн авч, буцаасан орлого болон бусад эх үүсвэрээс 39,9 сая төгрөгийн орлогыг оруулж нийтдээ 9774,7 сая төгрөгийн орлогыг хүлээн авсан байна.

Тодруулбал: Халамжийн сан нь төсвөөс 7252,2 сая төгрөгийн санхүүжилтийг авч, сангийн чөлөөт үлдэгдэлд бодогдсон хүүгийн орлогод 5,7 сая төгрөгийн, бусад орлогоос 17,9 сая төгрөгийн орлогыг оруулсан байна.

Хүнс тэжээлийн үйлчилгээний 698,7 сая төгрөгийн санхүүжилт авч, чөлөөт үлдэгдэлд 0,4 сая төгрөгийн хүүгийн орлого, буцаасан болон бусад эх үүсвэрээс 19,4 сая төгрөгийн орлого оруулсан байна.

ЖНХХЭТэтгэмжийн дансад 1406,2 сая төгрөгийн санхүүжилт авч, сангийн чөлөөт үлдэгдэлд 2,1 сая төгрөгийн хүүгийн орлого, бусад эх үүсвэрээс 2,6 сая төгрөгийн орлого оруулжээ. ОНОТХүйлчилгээнд 368,9 сая төгрөгийн санхүүжилт авч, сангийн чөлөөт үлдэгдэлд 0,3 сая төгрөгийн хүүгийн орлогыг оруулсан байна.

Сангийн зарцуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.Үүнд:

сан	Нийт орлого	Олголт	Банкны шимтгэл	Төсөвт төвлөрүүлсэн	Нийт зардал
алдарт эх	1,518,849,163.59	1,438,320,000.00	635,850.00	79,893,313.59	1,518,849,163.59
алдар цолтон	126,631,617.99	120,265,750.00	129,824.23	6,236,043.76	126,631,617.99
улсын төсвийн дүн	1,645,480,781.58	1,558,585,750.00	765,674.23	86,129,357.35	1,645,480,781.58
халамж	7,275,907,993.05	7,259,583,336.49	3,943,800.00	12,380,856.56	7,275,907,993.05
хүнс тэжээл	718,617,420.00	674,385,200.00	-	44,232,219.67	718,617,419.67
ЖХХХЭТэтгэмж	1,410,876,600.82	1,367,771,568.00	930,150.00	42,174,882.82	1,410,876,600.82
ОНОТХүйлчилгээ	369,266,710.18	331,475,439.00	12,450.00	37,778,821.18	369,266,710.18
орон нутгийн төсвийн дүн	9,774,668,724.05	9,633,215,543.49	4,886,400.00	136,566,780.23	9,774,668,723.72
нийт дүнгээр	11,420,149,505.63	11,191,801,293.49	5,652,074.23	222,696,137.58	11,420,149,505.30

Тайлант онд улсын төсвийн 2 санд нийт дүнгээр 1558,6 сая төгрөгийн санхүүжилт олгосны 1438,3 сая төгрөгийг алдарт эхийн санд, 120,3 сая төгрөгийг алдар цолтны санд тус тус олгосон байна.

Орон нутгийн төсвийн 4 санд нийт дүнгээр 9633,2 сая төгрөгийн санхүүжилт олгосны 7259,6 сая төгрөгийг халамжийн санд, 674,4 сая төгрөгийг хүнс тэжээлийн зардалд, 1367,8 сая төгрөгийг ЖХХЭ-ийн тэтгэмжинд, 331,5 сая төгрөгийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд тус тус зарцуулсан байна.

Банкны шимтгэлд нийт дүнгээр 5,6 сая төгрөгийг төлж, улсын төсөвт 86,1 сая төгрөгийн, орон нутгийн төсөвт 136,6 сая төгрөгийн орлогыг буцаан төвлөрүүлсэн байна.

Олгосон санхүүжилтийг сум тус бүрээр харуулбал: Алтай сумд 179,8 сая төгрөгийн, Алтанцөгц сумд 140,2 сая төгрөгийн, Баяннуур сумд 194,0 сая төгрөгийн, Бугат сумд 127,9 сая төгрөгийн, Булган сумд 218,9 сая төгрөгийн, Буянт сумд 120,9 сая төгрөгийн, Дэлүүн сумд 316,9 сая төгрөгийн, Ногооннуур сумд 248,2 сая төгрөгийн, Сагсай сумд 212,0 сая төгрөгийн, Толбо сумд 208,8 сая төгрөгийн, Улаанхус сумд 376,4 сая төгрөгийн, Цагааннуур сумд 40,6 сая төгрөгийн, Цэнгэл сумд 328,5 сая төгрөгийн, Өлгий сумд 8571,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон дүнтэй байна.

Нийгмийн халамжийн сангийн 2015 оны үйл ажиллагаанд нийтдээ 12622,9 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулахаар төсөв батлагдсанаас санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд орон нутгийн төсвөөс 10981,9 сая төгрөгийг, улсын төсвөөс 1641,0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тусгагдсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 9558,9 сая төгрөгийг зарцуулж, төсвийг 1423,0 сая төгрөгөөр, улсын төсвөөс 1557,8 сая төгрөгийг зарцуулж, төсвөө 83,2 сая төгрөгөөр буюу Халамжийн сангийн тайлант оны төсөв нийт дүнгээр 1506,2 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Тайлант оны төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

№	Төрөл	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Хувь
1	Халамжийн тэтгэвэр	5,139,731,000	4,700,964,195	91
2	Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1,517,146,000	1,352,621,395	89
3	Нөхцөлт мөнгөн тусламж, хөнгөлөлт	694,861,600	408,813,175	59
4	Ахмад настануудад үзүүлэх хөнгөлөлт	439,000,000	407,166,680	93
5	ХБИргэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ	300,371,000	295,388,617	98
6	Хүнс тэжээлийн тусламж, дэмжлэг	885,424,000	659,149,200	74
7	ОНОТХҮйлчилгээ	330,450,000	331,475,439	100
8	Жирэмсэн болон хөхүүл эхийн тэтгэмж	1,632,000,000	1,365,184,568	84
9	Банкны үйлчилгээний хураамж	5,400,000	5,652,074	105
10	АДЗ-ийн гишүүдийн урамшуулал	37,500,000	32,448,000	87
	Орон нутгийн төсөв	10,981,883,600	9,558,863,344	87
11	Алдарт эх	1,515,000,000	1,437,920,000	95
12	Алдар цолтон	126,000,000	119,865,750	95
	Улсын төсөв	1,641,000,000	1,557,785,750	95
	Төсвийн нийт дүн	12,622,883,600	11,116,649,094	88

Гүйцэтгэлээр тайлант оны Нийгмийн халамжийн сангийн орон нутгийн төсвийн 87 хувийг, улсын төсвийн 95 хувийг зарцуулсан дүнтэй байна.

Тухайлбал: Халамжийн тэтгэвэрт 4700,9 сая төгрөг зарцуулж батлагдсан төсвийн 91 хувийг, нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1352,6 сая төгрөг зарцуулж батлагдсан төсвийн 89 хувийг, нөхцөлт мөнгөн тусламжинд 408,8 сая төгрөг зарцуулж батлагдсан төсвийн 59 хувийг, ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлтөнд 407,2 сая төгрөг зарцуулж батлагдсан төсвийн 93 хувийг, ХБИ иргэнд үзүүлэх үйлчилгээнд 295,4 сая төгрөг зарцуулж батлагдсан төсвийн 98 хувийг, хүнс тэжээлийн дэмжлэг тусламжаанд 659,1 сая төгрөг зарцуулж батлагдсан төсвийн 74 хувийг, ЖНХХЭТэтгэмжинд 1365,2 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийн 84 хувийг, АДЗ-ийн урамшуулалд 32,4 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийн 87 хувийг, алдарт эхийн болон алдар цолтны тэтгэмжинд 1557,8 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийн 95 хувийг зарцуулжээ.

ОНОТХҮ-ний болон банкны үйлчилгээний хураамжийн төсвийг 100 хувь зарцуулсан дүнтэй байна.

Бүлэг 2

Зарим сангаас олгох тэтгэмжийг хууль зөрчиж олгосон байна.

Оршил

Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулинд халамжийн сан нь *тэтгэвэр, тэтгэмжийн болон нийгмийн үйлчилгээний сан* гэсэн төрөлтэй байхаар хуульчилсан байна.

Нийгмийн үйлчилгээний сангийн хөрөнгөөр амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээ, шинэ төрлийн үйлчилгээ турших болон хууль тогтоомжийн өөрчлөлтийн улмаас нийгмийн халамжаас хасагдсан иргэнд үзүүлэх үйлчилгээний зардал, амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийн гишүүн, сум хорооны нийгмийн ажилтанд олгох урамшуулал, нийгмийн ажилтаны чадавхийг бэхжүүлэх, мэргэшүүлэх сургалт, бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, шинэчлэхтэй холбогдсон зардал, нийгмийн халамжийн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх судалгаа, шинжилгээ, үнэлгээний зардал болон холбогдох бусад зардлыг санхүүжүүлэхээр хуульчилжээ.

Тэтгэвэр тэтгэмжийн сангаас халамжийн тэтгэвэр тэтгэмжийн олголт хийгддэг бол нийгмийн үйлчилгээний сангаас нөхцөлт мөнгөн тэтгэмж, нийгмийн халамжийн тусламжаа шаардлагатай өрх, иргэний амьжиргаанд дэмжлэг үзүүлэх хөнгөлөлт, тусламж, нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагаатай холбоотой хуульд заасан бусад зардлын олголт хийгдэж иржээ.

2.1 Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зарцуулалтын талаар

Халамжийн сангийн 2015 оны үйл ажиллагаанд хийх нийцлийн аудитын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, ахмад настан, ХБИ-д олгож буй хөнгөлөлт, тусламж болон ОНОТХҮйчилгээний зарцуулалт үр дүнтэй байгаа эсэхийг шалгаж, дүгнэлт, зөвлөмж өгөх зорилготой байсан боловч аудитын багийн гишүүдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн улмаас халамжийн тэтгэврийн зарцуулалт, олголтыг аудитад хамруулаагүй болно.

Тайлант онд халамжийн тэтгэвэрт 4700,9 сая төгрөгийг зарцуулж, 3186 хүнийг, нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1352,6 сая төгрөг зарцуулж, 1241 хүнийг, нөхцөлт мөнгөн тусламж, хөнгөлөлтөнд 408,8 сая төгрөгийг зарцуулж, 1927 хүнийг тус тус хамруулсан мэдээтэй байна.

2.2 Нэг удаагийн хөнгөлөлт, тусламжийн зарцуулалтын талаар.

Холбогдох хууль тогтоомжийг зөрчиж 18,0 сая төгрөгийн ихэр хүүхдийн тэтгэмжийг олгосон байна.

Нийгмийн халамжийн тэтгэмж нь асаргааны тэтгэмж, нийгмийн халамжийн дэмжлэг, тусламжаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний тэтгэмж,

онцгой тохиолдолын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж гэсэн төрөлүүдтэй байна.

Аудитаар онцгой тохиолдолын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг сонгон авч Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.4, 13.5.6, 13.5.7, 13.5.8, 13.5.9-д зааснаас бусад буюу 13.5.1-13.5.5-д хамаарах тэтгэмжийг сонгон авч шалгасан.

Санхүүгийн баримтуудаас түүвэрлэсэн гүйлгээнүүдийг халамжийн сангийн 2015 оны мэдээллийн баазтай тулган шалгах явцад зарим олгосон тусламж, хөнгөлөлтийн үндсэн баримтуудыг нь санхүүгийн баримтанд хавсаргаагүй орхисон зөрчил илэрч, орхигдсон үндсэн баримтуудыг нөхөж авахуулснаар дахин тулгалт хийж зөрчлүүдийг арилгууллаа. Зарим сумдаас олгосон тусламж, хөнгөлөлтүүдийн үндсэн баримтуудыг дутуу ирүүлсэн зөрчил илэрснийг арилган ажиллах, давтан гаргахгүй байхаар үүрэг өгч ажиллалаа.

Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг шалгасан аудитын дүнгээр:

- 2015 онд гэнэтийн аюул осолын улмаас гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон Бугат сумын 1 иргэнд, гэр оронгүй Өлгий сумын 3 иргэнд тус бүрт 1,2 сая төгрөгийн /МУЗГ-ын 2012 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 136 дугаар тогтоолд заасан/ онцгой тохиолдолын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.1-д заасны дагуу олгосон байна.

Энэхүү тэтгэмжийг олгохдоо МУЗГ-ын 2012 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам”-ын 4.17-д заасан “Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.1-д заасан тэтгэмж олгохдоо гамшгийн улмаас гэр оронгүй болсон, эсхүл гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон, өрхийн амьжиргааны эх үүсвэр болж байсан мал, амьтан, тээврийн хэрэгсэл, өрхийн үйлдвэрлэлийн байр, таримал ургамал (жимс жимсгэнэ, цэцэг, нарийн ногоо, өрхийн хүлэмж гэх мэт) болон тэдгээртэй адилтгах орлогын эх үүсвэрээ алдсан тухай мэргэжлийн (онцгой байдлын асуудал хариуцсан хэлтэс зэрэг) байгууллагын тодорхойлолтыг үндэслэнэ” гэсний хэрэгжилтийг шалгахад зарим иргэдэд онцгой байдлын хэлтсийн тодорхойлолтгүй олгосон буюу хуулийг хэрэгжүүлэх аргачлалыг мөрдөж ажиллаагүй байна.

- Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.3-д заасны дагуу хорих ангиас суллагдсан Өлгий сумын 2, Ногооннуур, Улаанхус, Булган сумын тус бүр 1, бүгд 5 иргэнд тус бүрд нь 1,2 сая төгрөгийн /МУЗГ-ын 2012 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 136 дугаар тогтоолд заасан/ онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг олгосон байна.

Энэхүү тэтгэмжийг олгохдоо “ШШГЕГ-аас жил бүр харъяа хорих ангиудад ял эдэлж байгаа, тухайн онд хорихоос суллагдах, гэр оронгүй иргэдийн судалгааг гаргаж НХҮЕГ-т ирүүлэх бөгөөд тус судалгаа, нэрсийн жагсаалтад орсон иргэдэд аймаг, дүүргийн НХҮХ-үүд нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.3-д заасан мөнгөн тэтгэмжийг олгоно”-гэсэн хуулийг хэрэгжүүлэх аргачлалыг мөрдөж ажиллаагүй байна. /2013 оны 07 дугаар сарын 08-ны өдөр НХҮЕГ-ын дарга, ШШГЕГ-ын даргатай байгуулсан “Хамтран ажиллах санамж бичиг”-ийн 3.5-д заасан/

Шалтгаан нь удаан жил ял эдэлж гарсан гэр оронгүй иргэний талаар тухайн ял эдэлж гарсан хорих ангиас жагсаалт гаргаж ирүүлдэггүйтэй холбоотой байна.

- 2015 онд 93 иргэнд 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны /Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.2/ иргэнд нэг удаа олгох тэтгэмжийг /МУЗГ-ын 2012 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 136 дугаар тогтоолд заасан хэмжээгээр/ иргэн бүрт 1,2 сая төгрөгийг буюу бүгд 111,6 сая төгрөгийг олгосон байна.

Баяннуур сумын халамжийн сангаас бүтэн өнчин хүүхэд болох Зейнепын Сарсенбайд, Улаанхус сумаас бүтэн өнчин хүүхэд болох Жүсипийн Жархын, Тайыншагийн Жанболат, Жуханы Бердимурат, Саниязын Нурсолтан нарт, Алтанцөгц сумаас бүтэн өнчин хүүхдийн тэтгэмж авсан Энхтуяагийн Мөнгөнчимэг, Хадайн Дауитбек нарт олгосон бүтэн өнчин хүүхдийн тэтгэмжийн бүрдүүлвэл зохих баримтууд санхүүгийн баримтанд үдэгдээгүй орхигдсоныг тухайн сумаас баримтуудыг нь авахуулж тулган шалгаснаар зөрчлийг арилгуулав.

Бүтэн өнчин хүүхдэд олгосон тэтгэмжийг сумуудаар авч үзвэл:

№	Сумууд	Бүтэн өнчин хүүхдийн тэтгэмж авсан иргэний тоо	Эзлэх хувь
1	Алтай	4	4.3
2	Алтанцөгц	9	9.7
3	Бугат	9	9.7
4	Булган	0	0.0
5	Буянт	3	3.2
6	Баяннуур	2	2.2
7	Дэлүүн	3	3.2
8	Ногооннуур	6	6.5
9	Толбо	3	3.2
10	Сагсай	14	15.1
11	Цэнгэл	9	9.7
12	Улаанхус	8	8.6
13	Цагааннуур	1	1.1
14	Өлгий	22	23.7
	Бүгд	93	100

18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон хүүхдийн тоо харьцангуй их байгаа явдалд анхаарал хандуулж, Улсын бүртгэлийн хэлтэст бүтэн өнчин хүүхдийн тэтгэмж авсан иргэдийн нэрсийн жагсаалтыг албан тоотой хүргүүлж, эдгээр иргэд нь бүтэн өнчин эсэх талаар тодруулга авсан.

Улсын бүртгэлийн хэлтсээс 14 хүүхдийн эцэг эх нь нас барсан, үлдсэн 79 хүүхэд нь үрчлэгдсэн хүүхэд болох талаар хариу ирүүлсэн байна. /Улсын бүртгэлийн хэлтсийн 2016 оны 10 дугаар сарын 1099 тоот /

Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.7-д заасаныг хэрэгжүүлэх аргачлалд “эцэг эх нь хоёул нас барсан, мөн төрүүлсэн эцэг эх нь байвч үрчлэн авсан эцэг эх

нь хоёул нас барсан нь орно” гэсэний дагуу бүтэн өнчин хүүхдэд олгох нэг удаагийн тэтгэмжийг зохих хууль журмын дагуу олгосон байна.

- 2015 онд хоёр ба түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх иргэнд олгох /Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.5-д/ тэтгэмжийг хоёр ихэр хүүхэд төрүүлсэн 27 иргэнд тус бүр 2,0 сая төгрөг буюу бүгд дүнгээр 54,0 сая төгрөгийн, 3 ихэр төрүүлсэн 1 иргэнд 9,0 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон байна.

Улаанхус сумын Бугыбайн Зоя, Алтанцөгц сумын Сапа Ахмарал, Тойчыбайн Гүлдана, Дүүрэн Алтанцэцэг нарт олгосон ихэр хүүхдийн тэтгэмжийн холбогдох материалуудыг санхүүгийн баримтанд үдэгдээгүй орхигдсоныг тухайн сумуудаас баримтуудыг нөхөн авахуулж, зөрчлийг арилгуулав.

Аудитын явцад Эрүүл мэндийн газарт хандаж 2015 онд төрсөн ихэр хүүхдийн судалгааг авахад халамжийн сангаас тухайн онд төрсөн гэж ихэр хүүхдийн тэтгэмж авсан зарим иргэдийн мэдээлэл зөрүүтэй байсан.Тухайлбал: Ихэр хүүхдийн тэтгэмж авсан 1 иргэн нь ганц хүүхэд төрүүлсэн, 3 иргэний төрөлтийн түүхийн талаар мэдээлэл гараагүй болно.

Иймд 2014, 2013 онуудад олгосон ихэр хүүхдийн тэтгэмжийг аудитад хамруулж, ЭМГазраас 2008-2015 онд төрсөн ихэр хүүхдийн талаар мэдээллийг, НХҮХэлтсийн 2013-2015 оны файлыг авч ихэр хүүхдийн тэтгэмжийг сонгож тулган баталгаажуулалт хийлээ.

2013 онд 107 иргэн ихэр хүүхдийн тэтгэмж, 2014 онд 30 иргэн ихэр хүүхдийн тэтгэмж авсан байна.

ЭМГазарт 2013-2015 оны ихэр хүүхдийн тэтгэмж авсан 87 иргэний жагсаалтыг албан тоотоор хүргүүлж, мэдээллийн санд байгаа эсэхийг тодруулав. ЭМГазраас 2016 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 591 албан тоотоор 36 эх ихэр хүүхэд төрүүлсэн, 29 эх ихэр хүүхэд төрүүлээгүй, 22 эхийн төрөлтийн талаар мэдээлэл олдоогүй гэсэн хариу ирүүлсэн.

Ихэр хүүхэд төрүүлсэн талаар мэдээлэл олдоогүй болон мэдээлэл, регистрийн дугаар зөрүүтэй 53 иргэний төрөлтийн түүхийг Нэгдсэн эмнэлгийн архиваас тулган шалгахад архиваас 15 иргэний 2008-2013 онуудад ихэр хүүхэд төрүүлсэн талаарх төрөлтийн түүх гарч, бусад ихэр төрөлтүүдийн түүх гараагүй болно.

Үлдсэн 38 иргэний мэдээллийг НХҮХэлтсийн өрхийн мэдээллийн сангаас шүүлт хийлгэж, шалгуулахад 26 иргэн ихэр хүүхэдтэй гэсэн мэдээлэл гарсан. Үүнээс 2003 оны 1 дүгээр сард ихэр хүүхэд төрүүлсэн 1, 2008 оны 5 дугаар сард ихэр хүүхэд төрүүлсэн 1 эхэд тус тус холбогдох журмыг зөрчиж, тэтгэмжийг /2012 оны 7 дугаар сар эсхүл энэ үед 4 насанд хүрээгүй байсан ихэр хүүхэд энэ арга хэмжээнд хамрагдана. ХАХНХ-ын сайдын “Тодруулга хүргүүлэх тухай” 2013 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 1/245 тоот албан тоотод/ олгосон нь тогтоогдсон. Бусад 24 иргэн хуулийн хугацаанд ихэр хүүхдийн тэтгэмж авсан байна.

НХҮХ-ийн Өрхийн мэдээллийн сангаас ихэр хүүхдийн тэтгэмж авсан 11 иргэний ихэр хүүхэд төрүүлсэн талаар мэдээлэл гараагүй, 2 иргэн нь хууль тогтоомж зөрчиж тэтгэмж авсан байна.

Сумуудаар нь авч үзвэл: Өлгий сумын 4, Бугат сумын 4, Дэлүүн сумын 2, Цэнгэл сумын 1, Толбо сумын 1, Улаанхус сумын 1 иргэн байна. Үүнээс: Цэнгэл, Толбо, Улаанхус сумуудад төрсөн ихрүүд сумд төрж, аймагт мэдээлэл өгөөгүй, Толбо суманд төрсөн ихэр хүүхэд нь Ховд аймагт шилжсэнтэй холбоотой өрхийн мэдээллийн сангаас гараагүй байна. Мөн Дэлүүн сумын 1 иргэн нь Ховд аймагт шилжин суурьшиж байгаатай холбоотой мэдээллийн санд ороогүй байна.

Аймгийн ЭМГ-ын мэдээллийн сан дахь ихэр хүүхдийн бүртгэл нь НХҮХ-ийн өрхийн мэдээллийн сан дахь ихэр хүүхдийн бүртгэлээс зөрүүтэй байна. ЭМГ-ын ихэр хүүхдийн бүртгэлд ороогүй 26 ихэр хүүхэд нь НХҮХ-ийн өрхийн мэдээлэлд ихэр хүүхдээр бүртгэгдсэн байна.

Ихэр хүүхдийн тэтгэмжийг шалгасан аудитаар дараах зөрчлүүд илэрсэн.Үүнд:

-Бугат сумын иргэн Имангажы овогтой Хундыз, Хасен овогтой Айна нарт 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр, Жалел овогтой Нуржанд 2013 оны 6 дугаар сарын 25-ний өдөр, Зейнелхан овогтой Саулегүлд 2013 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр тус тус ихэр хүүхдийн тэтгэмж олгосон боловч эдгээр иргэд нь ихэр хүүхэд төрүүлээгүй байгаа нь;

- 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр ихэр хүүхдийн тэтгэмж авсан Уатхан овогтой Алтынгүл нь 2003 оны 01 дүгээр сард төрсөн ихэр хүүхдийн тэтгэмж олгож хууль тогтоомж зөрчсөн нь;

- 2013 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр ихэр хүүхдийн тэтгэмж олгосон Өлгий сумын иргэн Ансаган овогтой Толганай, Хабылбай овогтой Батима нарын ихэр хүүхэд төрүүлээгүй болох нь, 2013 оны 5 дугаар сарын 20-ны өдөр ихэр хүүхдийн тэтгэмж олгосон Дуанбай овогтой Айсауле нь 2008 оны 5 дугаар сард ихэр хүүхэд төрүүлсэн боловч хууль тогтоомж зөрчиж ихэр хүүхдийн тэтгэмж олгосон болох нь тус тус ЭМГ-ын мэдээллийн сан, Нэгдсэн эмнэлгийн архив, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн өрхийн мэдээллийн сангаас авсан мэдээллээр нотлогдож байна.

Эдгээр иргэдэд хууль тогтоомж зөрчиж, хуурамч бичиг баримт бүрдүүлж ихэр хүүхдийн мөнгө олгосон нь төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна гэж үзэх бүрэн үндэстэй байна.

Дэлүүн сумын иргэн Уатхан овогтой Алтынгүл, Өлгий сумын иргэн Дуанбай овогтой Айсауле нарт Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам”-ын 4.7-д “Хоёр болон түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж, эсэн мэнд өсгөж байгаа эх, эцэг, асран хамгаалагчад хүүхэд нь 4 нас хүрэхээс өмнөх хугацаанд Засгийн газраас тогтоосон хэмжээгээр нэг удаа тэтгэмж олгоно”-гэснийг, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын “Тодруулга хүргүүлэх тухай” 2013 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 1/245 дугаар албан тоотод “2012 оны 7 дугаар сар эсхүл энэ үед 4 насанд хүрээгүй байсан ихэр хүүхэд энэ арга хэмжээнд хамрагдана” гэснийг тус тус зөрчиж ихэр хүүхдийн тэтгэмжийг олгосон байна.

Бугат сумын иргэн Имангажы овогтой Хундыз, Хасен овогтой Айна, Жалел овогтой Нуржан, Зейнелхан овогтой Саулегүл, Өлгий сумын иргэн Ансаган овогтой Толганай, Хабылбай овогтой Батима нар нь ихэр хүүхэд төрүүлсэн нь нотлогдохгүй байгаа нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.5-д “энэ

хуулийн 19.2.4-д зааснаас бусад 2 ба түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгоно” гэснийг, МУЗГ-ын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам”-ын 4.7-д “Хоёр болон түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж, эсэн мэнд өсгөж байгаа эх, эцэг, асран хамгаалагч-д хүүхэд нь 4 нас хүрэхээс өмнөх хугацаанд Засгийн газраас тогтоосон хэмжээгээр нэг удаа тэтгэмж олгоно”-гэснийг, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын “Тодруулга хүргүүлэх тухай” 2013 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 1/245 дугаар албан тоотод “2012 оны 7 дугаар сар эсхүл энэ үед 4 насанд хүрээгүй байсан ихэр хүүхэд энэ арга хэмжээнд хамрагдана” гэснийг тус тус зөрчсөн байна.

Дээрхи 9 иргэнд ихэр хүүхдийн тэтгэмжийг хууль тогтоомжийг зөрчиж олгосон нь нотлогдож байгаа тул нийтдээ 18,0 сая төгрөгийн тэтгэмжийг тухайн сумдын халамжийн мэргэжилтэн нараар хариуцуулан нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

2.3 Ахмад настан, ХБИ-д олгож буй хөнгөлөлт, тусламжийн зарцуулалтын талаар.

Ахмад настан, ХБИ-ний нийгмийн хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.1, 5.1.4, 5.1.8-д заасан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.3, 5.1.6, 5.1.10-д заасан хөнгөлөлт, тусламжийн зарцуулалтыг шалгасан.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.1-д “хөл гар, шүд /үнэт металлаар хийхээс бусад/ -ний протез, сонсох, харах эрхтний ортопедийн хэрэглэл худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлын үнийг 5 жил тутамд нэг удаа жишиг үнээр нөхөн олгох”, ХБИНХ тухай хуулийн 5.1.3-д “үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг 3 жил тутамд нэг удаа 100 хувь нөхөн олгох” гэсний дагуу тусламж, хөнгөлөлтийг олгосон байна. Тусламж, хөнгөлөлтийг олгохдоо холбогдох журмын дагуу бүрдүүлж ирүүлсэн материалыг НХҮХэлтсийн холбогдох мэргэжилтнээр мэдээллийн сангаас шүүлт хийлгүүлж, хянуулж, гарын үсэг зуруулсны дараа олгож иржээ. Бүх сумдын материалыг татан авч баримтын бүрдүүлэлтийг шалгахад зөрчил гараагүй болно.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.4-т “эмчилгээ сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настан эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох”-гэж заасны дагуу рашаан сувиллын газруудад амарсан ахмадууд амарч ирсэнийхээ дараа холбогдох бичиг баримтаа бүрдүүлэн сумын нийгмийн ажилтанд өгч эрхийн бичгийн болон замын зардлын хөнгөлөлтийг авсан байна. Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журмын 2.25-д “Ахмад настан нь жилд нэг удаа ахмадын зориулалттай амралт, сувиллын газарт амарч сувилуулсаны дараагаар сум, хорооны нийгмийн ажилтанд энэхүү журмын 3.3-т заасан баримт бичгийг бүрдүүлэн өгч, эрхийн бичгийн үнийн хөнгөлөлт авна” гэсэн заалтыг мөрдөж ажилласан байна. Хуулийн энэ заалтын дагуу 2015 онд 121 ахмад настан 15646,3 мянган төгрөгийн тусламж, хөнгөлөлтийг авсан байна.

ХБИНХТ хуулийн 5.1.6-гийн 5.1.6.а-д “Хөгжлийн бэрхшээлтэй 0-16 хүртлэх насны хүүхэд дотоодын рашаан сувилуулбал нэг талын унааны зардал, эрхийн бичгийн үнийн 100 хувийг жилд нэг удаа нөхөн олгох” гэсний дагуу хөгжлийн бэрхшээлтэй 0-16 насны 17 хүүхдэд 2451,0 мянган төгрөгийн хөнгөлөлтийг олгожээ.

ХБИНХТ хуулийн 5.1.6-гийн 5.1.6.б-д “Дотоодын рашаан сувилал шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн унааны нэг талын зардлын 50 хувь олгоно” гэсний дагуу 12 асран хамгаалагчид 1536,2 мянган төгрөгийн хөнгөлөлт, тусламжийг олгосон байна.

ХБИНХТ хуулийн 5.1.6-гийн 5.1.6 в-д “Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэний дотоодын рашаан сувилалд сувилуулах эрхийн бичгийн үнийн 50 хувийг олгоно” гэсний дагуу 2015 онд 154 иргэнд 19554,3 мянган төгрөгийн тусламж, хөнгөлөлтийг үзүүлжээ.

АННХТ хуулийн 5.1.8, ХБИНХ тухай хуулийн 5.1.10-д “нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд унааны нэг талын зардлыг жилд нэг удаа нөхөн олгох”-гэсний дагуу 2015 онд 330 ахмад настанд 70,8 сая төгрөгийн, 261 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 50,0 сая төгрөгийн унааны зардлын хөнгөлөлтийг тус тус олгосон байна.

Баяннуур сумын Смагулын Жазира, Байтаны Хавдал, Хусманы Камелхан, Алпенишийн Алтынгүл нарын, Буянт сумын Өрөстөөны Минжмэн, Цэнээгийн Нацагдорж нарын, Улаанхус сумын Рыс Жаналых, Байсалханы Төлен, Алтай сумын М.Тогтасын нарын замын зардал авсан баримтыг санхүүгийн баримтанд үдээгүй байсан холбогдох мэргэжилтнүүдэд үүрэг өгч зөрчлийг аудитын явцад арилгуулав.

АННХТ хуулийн 6.3-д “ажиллаж байсан ААН, байгууллага нь дампуурсан, буюу татан буугдсан, түүнчлэн өөр орон нутгаас шилжиж ирснээс харъяалах байгууллага, аж ахуйн нэгж байхгүй болсон ахмад настныг орон нутгийн захиргаа, нийгмийн халамжийн болон ахмад настны байгууллага билгийн тооллын хаврын тэргүүн сар-цагаан сарын шинийн нэгэн болон бусад тэмдэглэлт өдрийг хүлээн авч хүндэтгэл үзүүлнэ” гэсний дагуу уламжлалт Цагаан сарын баярыг тохиолдуулан аймгийн хэмжээнд нийт 343 ахмад настныг аймаг, сумын ЗДТГ-тай хамтран хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, гарын бэлэг гардуулсан байна.

Мөн “Наурыз”-ын баярыг тохиолдуулан аймаг, сумдын ЗДТГ-тай хамтарч 70-аас дээш настай ахмад настнуудын судалгааг гаргаж, хэлтсээс ажлын хэсэг томилон ажиллуулж, нийгмийн халамжийн сангаас нийт 1967 ахмад настанд 28695,0 мянган төгрөгийн гарын бэлэг гардуулах ажлыг зохион байгуулжээ.

Зарим сумдад Нийгмийн халамжийн тухай хуулинд тусгасны дагуу ахмад настнуудыг цагаан сарын болон наурызын баяраар хүлээн авахдаа сумдын санхүүгийн баримтанд холбогдох анхан шатны баримтуудыг хавсаргаагүйн дээр хүлээн авалтанд оролцсон хүмүүсийг үнийн дүнгүй жагсаалтанд гарын үсэг зуруулан хавсаргасан зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар үүрэг өгч ажиллав.

НХТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.2-д “Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сум, хорооны Засаг даргын санал болгосноор сум, хороонд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж батална” гэсний дагуу сум бүрт 7 хүний бүрэлдэхүүнтэй амьжиргааг дэмжих зөвлөлийг тус хуулийн 27.3-д заасан ажиллах бүрэлдэхүүн болон төлөөллийн дагуу байгуулсан байна.

АДЗөвлөл нь нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс бусад иргэнийг нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах эсэх талаар шийдвэр гаргаж, халамжийн үйл ажиллагаатай холбогдсон гомдлыг хүлээн авч шийдвэрлэж ажилласан байна.

Өлгий сумын ИТХурлын тэргүүлэгчдийн 2015 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 02 тогтоолоор Өлгий сумын 13 багт ажиллах амжиргаа дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнийг тус хуулийн 27.3-д заасан ажиллах бүрэлдэхүүн болон төлөөллийн дагуу баталж ажиллуулсан байна.

АДЗөвлөлийн нарийн бичгийн ажлыг сумын нийгмийн халамжийн ажилтан хийж хурлын тэмдэглэлийг тухай бүр хөтөлж, гишүүдийн хурлын ирц, цагийн бүртгэлийг аймгийн НХҮГ-т хүргүүлж ажиллажээ.

ХХҮХэлтсээс зохион байгуулж 2015 онд Аймгийн төвийн баг болон сум хариуцсан АДЗ-ийн нийт 156 гишүүнийг хамруулан төрийн болон төрийн бус байгууллагын холбогдох ажилтнуудаар оролцогсодыг мэдээллээр хангаж ажилласан байна.

НХТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.6-д заасны дагуу АДЗ-ийн үйл ажиллагаанд ИТХ-ын тэргүүлэгчид хяналт тавих талаар заасан боловч хяналт хийсэн материал байхгүй байгаа нь хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй гэж үзэх үндэстэй байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10-д “Зөвлөлийн гишүүнд болон сум, хорооны нийгмийн ажилтанд ажлын оролцоо, идэвх чармайлтыг харгалзан улиралд нэг удаа урамшуулал олгох бөгөөд уг урамшууллын хэмжээ, олгох журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлана”, 27.11-д “Энэ хуулийн 27.10-т заасан урамшууллын зардлыг халамжийн сангаас санхүүжүүлнэ” гэсэн заалтуудыг үндэслэж 2015 онд АДЗ-ийн гишүүдэд Нийгмийн халамжийн сангаас 32,0 сая төгрөгийн урамшуулал тооцож олгосон байна. Урамшууллыг улиралд нэг удаа, нэг гишүүнд 48,0 мянган төгрөгөөр тооцож олгожээ.

2015 онд амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдэд олгосон 32,0 сая төгрөгийн урамшууллаас 3,2 сая төгрөгийн татварыг суутгаагүй олгосныг орон нутгийн төсвийн орлогод Нийгмийн халамжийн сангаас нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Энэхүү зөрчил нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д “энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-д” төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого”-д заасан орлогын дүнд мөн хуулийн 23.1-д заасан хувиар татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”, Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн

18.1.6-д” бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх”, 29 дүгээр зүйлийн 29.1.5”-д татвар суутгагч хувь хүн, хуулийн этгээд нь бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод татвар ногдуулж, суутган авч төсөвт төлөөгүй бол түүнийг уг этгээдийн хөрөнгөөс нөхөн төлүүлэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

2.4 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зарцуулалтын талаар.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсвийг 320,0 сая төгрөгийг нэмж тодотгосон байна.

ОНОТХУ-ний төсөл хөтөлбөрт оны эхэнд 80,4 сая төгрөгийн төсөв батлагдснаас Төсвийн тухай хууль болон Нийгмийн халамжийн тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн аймгийн Засаг даргын 2015 оны 11 дүгээр сарын 25-ны А/580, 12 дугаар сарын 22-ны А/615 тоот захирамжаар олон нийтийн оролцоо төсөл, хөтөлбөр, үйлчилгээнд зорилтод бүлгийн хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор 2015 оны нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмжид хуваарлагдсан хөрөнгийн хэмнэлтээс 320,0 сая төгрөгийг хуваарилж, 400,4 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

ОНОТХ-ийн дансанд 2015 онд 350,0 сая төгрөгийн санхүүжилт, 0,3 сая төгрөгийн хүүгийн орлого, 25,4 сая төгрөгийн бусад орлого бүгд **375,7** сая төгрөгийн орлого орсоноос Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эхчүүдийн холбооны өмнөх оны өглөг болон сургалтын зардалд 25,9 сая төгрөгийг, бүлэг дэмжих төсөлд 301,1 сая төгрөгийг, аймгийн Эмэгтэйчүүдийн холбоонд сургалтын зардалд 3,0 сая төгрөгийг, Ахмадын холбоонд өдрийн үйлчилгээнд 1,0 сая төгрөгийг, ХБХ-ийн эцэг эх асран хамгаалагч нарт зөвлөгөө өгөх сургалтанд 1,1 сая төгрөгийг, Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан аймгийн хэмжээнд тэмцээн зохион байгуулах 2,6 сая төгрөгийг, өрхийн хөгжлийн төлөвлөгөөнд хамрагдсан өрхийн гишүүдийг мэдээллээр хангахад 2,5 сая төгрөгийг, “Гар урлал” уралдаан зохион байгуулахад 0,3 сая төгрөгийг, ХБХүүхдүүдэд гарын бэлэгт 0,5 сая төгрөгийг, банкны шимтгэлд 0,01 сая төгрөгийг, бүгд **338,0** сая төгрөгийг зарцуулж, 37,7 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсөл хэрэгжүүлээгүй нэг бүлгийн 1,5 сая төгрөгийг 2016 оны 1 дүгээр сард эргүүлэн төлүүлж, данс бүртгэлд тусгажээ.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1-д Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 9 төрлийн үйлчилгээ үзүүлэхээр заасан бөгөөд тус аймагт 4 төрлийн үйлчилгээг хэрэгжүүлж зорилтод бүлгийн 1037 иргэнийг хамруулжээ.

Амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг нь дэмжих зорилгоор зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах үйлчилгээнд 217 иргэнийг хамруулан 27,3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.9-д заасны дагуу зорилтот бүлгийн иргэдийг чадавхижуулах, орлогын эх үүсвэртэй болоход нь туслах зорилгоор жил бүр амьжиргааны түвшин ахиулахаар сонгогдсон өрхөөс өөрсдийн санаачлагаар

бүлгийн зохион байгуулалтад оруулж хамт олны бүлэг бүрдүүлэн 2015 онд 252 бүлгийн 541 иргэнд нийгмийн халамжийн сангаас 301,1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

2014, 2015 онд сумдад төслөөр олгогдсон санхүүжилтийн судалгаа

№	Сумын нэр	2014 он			2015 он		
		Бүлгийн тоо	Хүний тоо	Мөнгөн дүн	Бүлгийн тоо	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Алтай сум	1	2	1,000,0	1	2	1,200,0
2	Алтанцөгц	1	2	1,500,0			
3	Баяннуур	1	2	1,400,0	3	6	4,280,0
4	Бугат	1	2	1,300,0	5	10	7,280,0
6	Буянт				2	4	2,800,0
8	Ногооннуур				1	2	1,400,0
9	Сагсай				4	8	5,680,0
10	Толбо				3	6	3,880,0
11	Улаанхус				4	8	5,680,0
12	Цагааннуур	1	2	800,0	1	2	1,200,0
14	Өлгий	8	21	8,450,0	228	493	267,700,0
	Нийт дүн	13	31	14,450,0	252	541	301,100,0

2015 онд ОНОТХҮ-ний төсөв нь урьд онтой харьцуулахад 286,6 сая төгрөгөөр буюу 20,8 дахин, хамрагдсан иргэдийн тоо 239 иргэнээр буюу 19,4 дахин өссөн нь дүнтэй байна.

НХҮЕГ-ын даргын 2014 оны 66 тоот тушаалын 9-д “иргэдийн ирүүлсэн төслийг амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. АДЗ-өөр дэмжигдсэн төслийг Нийгмийн халамжийн үйлчилгээний хэлтэс хянаж үзээд хэрэгжих магадлалтай бол 1,5 сая хүртэлх төгрөгөөр санхүүжүүлнэ” гэснийг мөрдөн ажилласан байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төслийн хамралтын байдлыг хүснэгтээр харуулахад:

	Ахмад настан	ХБИ	Бүгд	Хувь	Төсөлд хамрагдсан хүний тоо /дунджаар/	хувь	мөнгөн дүн	хувь
Бусад сумууд	4450	4526	8976	58.2	24	9.5	33.4	11.1
Өлгий сум	3069	3388	6457	41.8	228	90.5	267.7	88.9
ДҮН			15433	100.0	252	100.0	301.1	100.0

Аймгийн Нийгмийн халамжийн сангийн мэргэжилтний гаргаж ирүүлсэн судалгаагаар 2015 онд Нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр авагч ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй нийт 15433 иргэн байгаагаас Өлгий сумд 6457 иргэн буюу 41,8 хувь нь, бусад сум тосгонд 8976 иргэн буюу 58,2 хувь оршин сууж байна.

Тайланд онд ОНОТХҮ-ний төслөөр Өлгий сумын 228 төсөлд 267,7 сая төгрөгийг олгосон нь нийт төсвийн 90,5 хувийг, бусад сумдаас шалгаруулсан 24 төсөлд 33,4 сая төгрөг олгосон нь нийт төсвийн 9,5 хувийг эзэлж байна.

ОНОТХҮ нь зорилтод бүлгийн өрх иргэнийг орлогын эх үүсвэртэй болгоход чиглэгдэх боловч нийт төсвийн 9,5 хувийг сумдад хуваарилсны дээр Булган, Дэлүүн, Цэнгэл сумдууд нь төслийн санхүүжилтийг хоёр жил дараалан олгоогүй байгаа нь төслийн талаар мэдээлэл хангалтгүй байгаатай холбоотой гэж үзэхээр байна.

Төслийг цаашид тогтвортой хэрэгжүүлж, сумдыг жигд хамруулах, төсөлд хамруулах иргэдийн судалгааг гаргаж, хуваарилалтыг оновчтой хийхэд анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэв.

Аудитын явцад Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн НХХАХөгжил хариуцсан албаны дарга Х.Назымгүл, Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн С.Еркеш, ОНОТХҮ хариуцсан мэргэжилтэн Х.Хаби, Халамжийн сан хариуцсан мэргэжилтэн Ж.Отгонцэцэг нарын хамт Өлгий сумын багуудын зарим төслийн санхүүжилт авсан иргэдтэй уулзаж төслөөр хийсэн ажилтай танилцав. Үүнд:

2-р багаас С.Айнагул, Н.Зоя, А.Сейлхан, 3-р багаас Н.Макен, Х.Айгул, 4-р багаас З.Оюун, Б.Тилеген, 5-р багаас Ч.Өлзийсүрэн, 6-р багаас М.Хумарбек, Х.Медихат, Б.Сагай, 8-р багаас Х.Бибати, Д.Келешек, С.Алмажан, 9-р багаас Б.Еркин, С.Айжан, Ш.Өнергул, Д.Аня, Б.Гүлшаш, 10-р багаас Х.Асханбек, 11-р багаас Х.Жыргаубек, Б.Сарсенбай, 12-р багаас К.Бахытгул, 13-р багаас М.Арнур, К.Муратбек, М.Аягөз, Д.Күлимхан нийт 28 бүлгийн 26 төслийн хэрэгжилтийг газар дээр нь үзэж танилцахад Б.Сагай болон Б.Гүлшаш нарын “Оёдол” төслүүд тодорхой шалтгаанаар хэрэгжээгүй, бусад төслүүд хэрэгжсэн байна.

Аудитын явцад иргэдээс Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсөлд хамрагдсан бүлгүүдэд олгосон төсөв нь харилцан адилгүй, олгосон төсвийн тодорхой хувийг халамжийн ажилтнууд хүртдэг гэсэн гомдлыг төслийн хэрэгжилтийг шалгах явцад тодруулж үзэхэд нотлогдоогүй байгаа болно.

Бүлэг 3

*Сангийн үйл ажиллагаанд тавих хяналтын үр нөлөөг
сайжруулах шаардлагатай байна.*

3.Нийгмийн халамжийн сангийн зарцуулалтанд тавьж буй хяналтын талаар.

Сангийн үйл ажиллагаанд тавих хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын нэгж нь үйл ажиллагаандаа МУ-ын ЗГ-ын 311 тоот тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-д нийцүүлэн байгууллагын хяналт шинжилгээ үнэлгээний журам боловсруулан батлуулж ажилласан байна.

МУ-ын ЗГ-ын 311 тоот тогтоолын 3.5-д “Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ” гэж заасны дагуу тус байгууллагын дотоод хяналтын нэгж 2015 онд 4 удаа хуралдаж, дотоод хяналтын чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан, байгууллагын үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг 3 төрлөөр ангилан эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө гарган ажилласан байна.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу дараах хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна.Үүнд:

1. 2014-2015 оны сумдын халамжийн сангуудын санхүүгийн баримт, халамжийн сангаас үйлчилгээ авагч иргэний хувийн хэрэг материалд болон нийгмийн ажилтнуудын дотоод ажилд хяналт шалгалт хийж, зөвлөмж өгч ажилласан байна.
ОНОТХҮ-ний хэрэгжилт, хүнс тэжээл хөтөлбөрийн хүнс нийлүүлэгч байгууллагын үйл ажиллагаанд сард 2 удаа хяналт хийж ажилласан байна.
Хүнсний эрхийн бичиг авсан иргэдийн мэдээллийг нягталж, тандалтаар газар дээр нь очиж танилцахад мэдээллийн зөрүүтэй 19 өрх гарсан байна.
Тухайлбал: 9 өрх машинтай боловч судалгаанд машинтай эсэхээ оруулаагүй, 3 өрх ажил эрхэлдэг тогтмол орлоготой гэдгээ бичүүлээгүй, 2 өрх 100-гаас дээш толгой малтай ба мөн хэд хэдэн өрх олон өрөө тохилог байртай, удаан эдэлгээтэй эд хогшилтой, боломжийн амьдралтай байсан тул АДЗ-ийн хурлаар хэлэлцүүлж түдгэлзүүлсэн байна
2. Хүн амын хөгжлийн нийгмийн хамгааллын сайдын 2015 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Хүнсний эрхийн бичиг олгох босго оноог нэмсэнтэй холбоотой, АДЗ-ийн гишүүдтэй хамтран шинээр хамрагдсан 42 өрхөд баталгаажуулалт хийж 39 өрхийг түтгэлзүүлсэн.

3. Сумдын зөвлөлийн гишүүдтэй уулзалт зохион байгуулж, үйл ажиллагаатай танилцаж “амьжиргаа дэмжих зөвлөл”-ийн хурлын шийдвэрт хяналт хийн, зөвлөлийн ажлыг дүгнэж ажилласан байна
4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдахаар шалгарсан бүлгүүдийн баримтын бүрдүүлэлтийг дотоод хяналтаар хянуулсаны дараа санхүүжүүлсэн байна.

Сумдын халамжийн сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын үр дүн болон шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаархи ажлын тайланг хэлтсийн даргад танилцуулж, холбогдох сумдын мэргэжилтнүүдэд зөрчил дутагдлыг арилгуулах талаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан байна.

Дотоод хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, биелэлтийг гаргаж ажилласан гэх боловч хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг мөнгөн дүнгээр илэрхийлээгүй, зөрчил гаргасан холбогдох ажилтануудад хариуцлага тооцоогүй байгаа нь хийгдсэн дотоод хяналт шалгалт нь ач холбогдол багатай болсон гэж үзэх үндэстэй байна.

3.2 Халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааг олон нийтэд ил тод мэдээлж ирсэн эсэх талаар.

Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааг олон нийтэд ил тод мэдээлж ажилласан байна.

Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүнд сурталгүй, ил тод нээлттэй үзүүлэх, байгууллагын үйл ажиллагааг иргэд олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагуудад сурталчилах, мэдээлэх зорилгоор ил тод мэдээллийн самбартай болж, телевизээр байнга мэдээлэл хийж, санал хүсэлтийн хайрцаг ажиллуулан иргэдийн санал хүсэлт өргөдлийг хүлээн авч, хугацаанд нь шийдвэрлэн ажилласан байна. *Тухайлбал:*

- Амьжиргааг дэмжих зөвлөлөөс гарсан шийдвэр, нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын тайлан, мэдээг мэдээллийн самбарт байршуулан, иргэдэд ил тод байдлаар хүргэсэн байна.
- Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ холбогдох байгууллагаар хянуулан, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбар бусад мэдээллийн хэрэгслээр мэдээлж ирсэн байна.
- Байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод байлгахад чиглэж, олон нийтийн санал асуулгыг сонсох, өргөдөл гомдол, мэдээллийн мөрөөр тодорхой арга хэмжээ авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.
- Байгууллагын үйл ажиллагаа, санхүү, төсөв, халамжийн сангийн мэдээллийг www.Halamj.gov.mn, www.Shilendans.mn цахим хуудсанд тухай бүр байршуулан ажилласан байна.

3.3 Нийгмийн халамжийн сангийн хөрөнгө нь эзэндээ хүрч байгаа эсэхэд тавьж буй хяналт, хуулийн сурталчилгааны талаар.

Нийгмийн халамжийн сангийн хөрөнгө нь зорилтот бүлэгт бүрэн хүрч байна гэж үзэх боломжгүй байна.

НХҮХ-ээс сангийн хөрөнгийг эзэндээ хүргэх, хууль сурталчилах талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.Үүнд:

- Сангийн хөрөнгийг аль болох зорилтот бүлэгт чиглүүлэн зарцуулахад анхаарч ажилласан байна.
- Нийгмийн халамжийн хуулийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдах иргэдийг оновчтой сонгон тэдний хэрэгцээний дагуу хуулийн хүрээнд үйлчлэх, сангийн зарцуулалтыг үр ашигтай, үргүй зардал гаргахгүй байх талаар арга хэмжээ авч ажилласан байна.
- Алдар цолтон, ахмад настан болон алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох тэтгэмж хөнгөлөлтүүд болон нэг удаа олгох хөнгөлөлт тэтгэмжүүдийн материалыг нэг бүрчлэн шалган шаардлага хангасан өрх, иргэдэд хуулийн дагуу олгоход хяналт тавьж ажилласан байна.

Дээрхи байдлаас харахад сангийн хөрөнгийг аль болох зорилтот бүлэгт чиглүүлэх, эзэндээ олгох талаар хяналт тавьж ажиллаж ирсэн боловч сум, баг тус бүрээр хийгдсэн зорилтот бүлэг бүхий хүмүүсийн нэгдсэн судалгаа байдаггүй, нийгмийн ажилтнууд нь зорилтот бүлгийн хүмүүстэй тулж ажилладаггүй зэрэг нь сангийн хөрөнгө эзэндээ бүрэн хүрч байна гэж үзэх боломжгүйд хүргэж байна.

Иймд НХҮХ-ийн зүгээс аймаг, сумын баг тус бүрээр судалгаа хийснээр халамжийн сангийн үйлчилгээ хүртэхээр иргэдийн нэгдсэн судалгааг гаргаж, сангийн хөрөнгийг зорилтот бүлгийн хүмүүст хүргэж ажиллах нь зүйтэй талаар зөвлөмж хүргүүлэв.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төлөвлөлт үндэслэл муутай хийгдэж ирсэн байна.
2. Зарим сангаас олгох тэтгэмжийг хууль зөрчиж олгосон байна.
3. Сангийн үйл ажиллагаанд тавих хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Хөдөлмөр, нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Съезхан, сангийн нягтлан бодогч Ш.Маржангул нарт:

1. Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг бодит тоо мэдээлэл, судалгаанд үндэслэн төлөвлөх;
2. Нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдах зорилтот бүлгийн иргэдийн нэгдсэн судалгааг аймаг, сумын хэмжээнд хийж, сангийн хөрөнгийг зорилтот бүлэгт чиглүүлэхэд анхаарч ажиллах;
3. Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулж, сангийн хөрөнгийг хууль журам зөрчиж олгох явдлыг таслан зогсоох арга хэмжээ авч ажиллах;
4. ОНОТХҮ-ний үр дүнг тооцож ажиллах;

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал

(Хөдөлмөр, нийгмийн халамж үйлчилгээний хэлстээс ирүүлсэн санал)

Баян-Өлгий аймгийн ХХҮГазар

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН 2015 ОНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТЭНД ӨГСӨН ТАЙЛБАР

№	Дүгнэлт	Тайлбар
1	Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төлөвлөлт үндэслэл муутай хийгдэж ирсэн байна.	Тухайн онд хэдэн хүн жирэмслэх, хөдөлмөрийн чадвараа алдах, нас барах, хэдэн өрхийн амьжиргааны түвшин доошлох, дээшлэх, хэдэн өрх гамшигт өртөх, хэдэн иргэн хорих ангиас суллагдах зэргийг төсөөлөх боломжгүй тул халамжийн тэтгэвэр, тэтгэмж жил бүр нэмэгдэж байгааг үндэслэн өнгөрсөн жилийн батлагдсан төсвийг нэмэгдүүлэх замаар нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг төлөвлөж байгаа билээ
2	Зарим сангаас олгох тэтгэмжийг хууль зөрчиж олгосон байна	2015 онд Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.1-д заасны дагуу гэнэтийн ослын улмаас гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон Бугат сумын иргэнд онцгой тохиолдолын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж олгосон бөгөөд уг тэтгэмжийг авахаар бүрдүүлсэн материалд аймгийн Онцгой байдлын газрын Улсын байцаагчийн дүгнэлт байгаа тул хууль зөрчиж олгоогүй болно. Мөн онд Өлгий сумын гэр оронгүй 3 иргэнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.4-д заасны дагуу онцгой тохиолдолын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж олгосон бөгөөд уг тэтгэмж олгоход Онцгой байдлын газрын Улсын байцаагчийн дүгнэлтийг шаарддаггүй бөгөөд бүрдүүлэх материалын жагсаалтанд байгаа Улсын бүртгэлийн газрын дүгнэлтийг хавсаргасан болно. АДЗөвлийн гишүүдэд олгосон 32, сая төгрөгийн урамшуулалаас ХАОАТатзар суутгаагүй бөгөөд тухайн онд суутгаж Нийгмийн халамжийн санд нөхөн төлүүлэх болно. 2013 онд хууль зөрчиж олгосон 18,0 сая төгрөгийн ихэр хүүхдийн тэтгэмжийг тухайн иргэнд хариуцуулж Нийгмийн халамжийн санд нөхөн төлүүлэх болно.
3	Сангийн үйл ажиллагаанд тавих хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна	Сангийн үйл ажиллагаанд тавих хяналтын үр нөлөөг сайжруулах ажиллах болно.

НХҮХ-ийн саналд тусгагдсан зүйл нь аудитын тайланд дурьдагдсан учраас өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.БЕКЕН

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

М.АЙНУР

АУДИТОР

Д.НАЗГҮЛ

АУДИТОР

Х.МАНАРГҮЛ